



A/a

ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 08 сарын 01 өдөр

Дугаар А/161

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.10, 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1, 8.1 дүгээр зүйлийн 13.18, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12, 9 дүгээр зүйлийн 9.1.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.3, 19.18 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тусгай зөвшөөрлийн комиссын ажлын албаны 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 07 дугаар хурлын шийдвэрийн дагуу Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах байгууллагын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Тусгай зөвшөөрөл авсан байгууллагыг арга зүйгээр хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газар (Г.Цэцэнсанаа)-т, Чанарын хяналтын газар (Ч.Отгонцэцэг)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Л.Батзориг)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Н.ЭРДЭНЭБАЯР

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын
газрын даргын 20... оны ... дугаар сарын ...-ны
өдрийн ... дугаар тушаалын хавсралт
161



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦАА СУНГАХ БАЙГУУЛЛАГУУД

№	Байгууллагын нэр /РД/	Үйл ажиллагааны чиглэл	Хаяг байршил	Хугацаа
1.	Си эл даблью ХХК РД: 6176798	Эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүн импортлох-ханган нийлүүлэх	ХУД, 15-р хороо, Фидес төвийн байр 5 давхарт	2030.06.15
2.	Тайёо таун корпораци ХХК РД: 5617863	Эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүн, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж импортлох-ханган нийлүүлэх	БГД, 26-р хороо, Дунд гол 52-р барилга 3 давхар 301 тоот	2030.06.15
3.	И эл ди эй ХХК РД: 5147751	Эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл импортлох-ханган нийлүүлэх	СХД, 29-р хороо, Москва хороолол 121-А байр 603 тоот	2030.07.21
4.	Цагаан овоо фарм ХХК РД: 2789086	Эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүн импортлох-ханган нийлүүлэх	ЧД, 3-р хороо, Жуулчны гудамж 48-2 тоот	2030.06.15
5.	Аюур мед дэвшил ХХК РД: 6553884	Эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүн импортлох-ханган нийлүүлэх	СБД, 8-р хороо, Бага тойруу, Б.Алтангэрэлийн гудамж, 5 дугаартай барилга, 902 тоот	2030.06.08